



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Нийрамдал талбай, Баян-Өндер сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 05. 11 № С7-112-12/2469
таний -ны № -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ
КОМПАНИУДАД

Хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Хүнд даацын өөрөө буулгагч автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102680 дугаартай тендерт оролцогчоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ([www.tender.gov.mn](#)) дамжуулан гаргасан тодруулгын хариут хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

612407010251

**ЭҮТӨҮГ/20240102680 ДУГААРТАЙ “ХҮНД ДААЦЫН ӨӨРӨӨ БУУЛГАГЧ
АВТОМАШИН” НИЙЛҮҮЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
ТОДРУУЛГЫН ХАРИУ**

2024-04-25

ТОДРУУЛГА:

Сайн байна уу? Гадаад улсын хуулийн этгээд Хүнд даацын өөрөө буулгагч автомашин 130тн нийлүүлэх тендерт оролцож байгаа юм

1. 0.5% тендерийн баталгааг заавал гадаад улсаасаа байршуулах уу? эсвэл албан ёсны дистрибутер компани нь дансанд байршуулаад тодорхойлолтыг тендерт хүргүүлж болох уу?
2. Гадаад этгээд буюу хягад улсад байрлаж байгаа хуулийн этгээд тоон гарын үсгээр хэрхэн баталгаажуулж материалыа илгээх вэ? албан ёсны дистрибутер монгол улсын хуулийн этгээдээр дамжуулан илгээнэ гэсэн үг үү?

ТОДРУУЛГЫН ХАРИУ:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг захиалагчид тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр гаргаж болно” гэж заасны дагуу танай компани тодруулга гаргахдаа тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар бус, тендер бэлдэхтэй холбоотой асуудлаар тодруулга авахыг хүссэн байна.

Захиалагч тухайн тендерт оролцогчдод тендер бэлдэхтэй холбоотой зөвлөгөө өгөх нь бусад оролцогчдын өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэх тул “Хүнд даацын өөрөө буулгагч автомашин” нийлүүлэгчийн сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь оролцогчдын тендер бэлдэхтэй холбоотой асуудлаар арга зүйн зөвлөгөө өгөх боломжгүй юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4-т “цахим системийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч, оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах” гэж зохицуулсан байна.

Иймд тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичигт нийлцүүлэн захиалагчаас тодруулга авахыг мэдэгдэж байна.

Үнэлгээний хорооны дарга:

Т.Түмэн-Өлзий

Үнэлгээний хорооны нарийн бичиг:

Т.Ууганбаяр

ЭҮТӨҮГ/20240102680 ДУГААРТАЙ “ХҮНД ДААЦЫН ӨӨРӨӨ БУУЛГАГЧ
АВТОМАШИН” НИЙЛҮҮЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
ТОДРУУЛГЫН ХАРИУ

2024-04-25

ТОДРУУЛГА:

1. Техникийн тодорхойлолт хэсгийн 4.Баталгаа хэсэгт:
Автосамосвалыг ашиглалтад орсноос хойш үндсэн эд анgid 15000 мото цаг буюу 2 жилийн аль түрүүлж хүрснээр, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, суурилсан нэгж бүрд хүлээн авснаас хойш хамгийн багадаа 8000 мото цаг буюу 1 жилийн аль түрүүлж хүрснээр үйлдвэрлэгчийн баталгаа олгоно гэж заасан байна. Үүний 15000 цагт хамаарах үндсэн эд анги гэдэгт юу орсон талаар, 8000 цагийн дагалдах болон суурилсан нэгжид юу хамаарах талаар жагсаалгаар ирүүлж өгнө үү.

ТОДРУУЛГЫН ХАРИУ:

1. “Автосамосвалыг ашиглалтад орсноос хойш үндсэн эд анgid 15000 мото цаг буюу 2 жилийн аль түрүүлж хүрснээр” гэдэгт автосамосвалын дотоод шаталтын хөдөлгүүр болон автосамосвалын тэвш гэж ойлгоно.
2. “Тэдгээрийн дагалдах хэрэгсэл, суурилсан нэгж бүрд хүлээн авснаас хойш хамгийн багадаа 8000 мото цаг буюу 1 жилийн аль түрүүлж хүрснээр” гэдэгт дотоод шатлалын хөдөлгүүр болон автосамосвалын тэвшнээс бусад эд ангийг гэж ойлгоно.

Үнэлгээний хорооны дарга:

Т.Түмэн-Өлзий

Үнэлгээний хорооны нарийн бичиг:

Т.Ууганбаяр